



1. Аудитын нэр:

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт

2. Аудитын код:

УАГ-НАГ/2017/07-НА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан "Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө"-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөгдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар болон холбогдох яам, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, Засаг даргын Тамгын газрыг хамруулна.

6. Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг

тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн зорилт чиглэсэн байна.

Энэхүү хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад зааснаар “Хөгжлийн бодлогын баримт бичиг”-ийг “үндэсний, салбарын, салбар хоорондын болон бус нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичиг” гэж тодорхойлж өгсөн байна.

Үндэсний хөгжлийн газрын 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 01/753 дугаар албан бичгээр ирүүлсэн судалгаа, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас авсан судалгааны дүнг нэгтгэхэд үндэсний, салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх 774 орчим хөгжлийн бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр байгаагаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 634 бодлогын баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан байна.

Хүснэгт 1. Хөгжлийн бодлогын баримт бичиг, түүний төрөл

Бодлогын баримт бичгийн төрөл	Бодлогын баримт бичиг	Дүн	Хууль хэрэгжиж эхэлснээс хойш
Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.1/	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал /Хуулийн 7 дугаар зүйл/	4	1
Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.2/	Төрөөс баримтлах бодлого /Хуулийн 8 дугаар зүйл/ Бүсчилсэн хөгжлийн бодлого /Хуулийн 13 дугаар зүйл/ Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт /Хуулийн 14 дугаар зүйл/	31 1 32	5 - 14
Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.2/	Сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлого /Хуулийн 14 дугаар зүйл/ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /Хуулийн 9 дугаар зүйл/ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /Хуулийн 15 дугаар зүйл/ Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр /Хуулийн 10 дугаар зүйл/ Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /Хуулийн 11 дүгээр зүйл/	72 1 335 94 1	50 1 333 26 1
Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх /Хуулийн 6.1.3/	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /Хуулийн 12 дугаар зүйл/ Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /Хуулийн 16 дугаар зүйл/ Улс, орон нутгийн төсөв Нийт	201 1 774	201 1 634

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газрын 2017 оны 08 дүйвэр сарын 21-ний өдрийн 01/753 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллаагаас ирүүлсэн судалгаанаас.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахад Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг

журам"-ыг баримталж бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг тус тус мөрдөж байна.

Доорх бодлогын баримт бичгийг хүснэгтэд заасан үндэслэлээр аудитад хамруулаагүй болно.

Хүснэгт 2

№	Баримт бичиг	Хуулийн заалт	Тайлбар /үндэслэл/
1	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	11 дүгээр зүйл	Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу жил бүр Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 ¹ дэх хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэлийн аудит хийж хүргүүлдэг.
2	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	12 дугаар зүйл	Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу жил бүр "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтэд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэлийн аудит хийж хүргүүлдэг.
3	Улс, орон нутгийн төсөв	6 дугаар зүйлийн 6.5.3	Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу жил бүр Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэлийн аудит хийж хүргүүлдэг.

7. Эрсдлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн ўе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг "Дунд" гэж үнэлсэн. (Эрсдэлийн үнэлгээг Хавсралт №1-д үзүүлэв)

8. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглана.

9. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;

¹ Хөтөлбөр болон Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

- Засгийн газрын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх “Үндэсний хөтөлбөр”-ийн жагсаалт;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Наранцэцэг, аудитор Ц.Цэрэннамжил, Л.Нямтөмөр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж, гэрээт шинжээч нарын хамт хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

11. Аудитын хугацаа:

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2017 оны 09.дүгээр сарын 04-өөс 10 дугаар сарын 06-ны хооронд, талбарын үе шатны ажлыг 2017 оны 10 дугаар сарын 09-өөс 12 дугаар сарын 31-ний хооронд гүйцэтгэж, нэгдсэн тайлангийн төслийг 2018 оны 02 дугаар сарын 01-ний дотор бэлтгэж, үе шатны хяналтаар оруулан МУЕА-ын тушаалаар баталгаажуулан 2018 оны 03 дугаар сарын 03-нд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Орон нутаг дахь Төрийн аудитын газрууд хуулиар тодорхойлсон бодлогын баримт бичгийг төлөвлөгөөнд заагдсан зорилтын хүрээнд шалгаж 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор тайлан, холбогдох судалгааны маягтыг ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт файлаар (цахим хаяг: tserennamjilts@audit.gov.mn, nyamtumurl@audit.gov.mn) болон цаасаар ирүүлнэ.

12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх, хоёрдугаар бүлэгт Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, гуравдугаар бүлэгт Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх талаар тусгана.

13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

A. Хүний нөөц:

- ҮАГ-аас 5 хүн: 90 өдөр, нийт 450 хүн/өдөр

- Орон нутгаас: 44 хүн 65 өдөр, нийт 2860 хүн/өдөр
- Гэрээт шинжээч 3 хүн, нийт 65 өдөр, нийт 195 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц:

- цалин 303,517.2 мянган төгрөг
- гэрээт шинжээч 9,750.0 мянган төгрөг
- томилолтын зардал: 8,042.6 мянган төгрөг
- ойилсон бүлгийн ярилцлага: 1,000.0 мянган төгрөг

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, дектафон, скайнер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг

Танилцсан:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ОЮУНБИЛЭГ

Хянасан:

НИЙЦЛИЙН АУДИТИН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.АЛТАНЗУЛ

АУДИТИН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.НАРАНЦЭЦЭГ
Ц.ЦЭРЭННАМЖИЛ
Л. НЯМТӨМӨР

Хавсралт №1

УХА0122

Аудитын эрсдлийн үнэлгээ

№	Эрсдэл	Магадлал	Үр дагавар	Үнэлгээ
1	Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөхөд хуулийн 5.1.1-5.1.7-д заасан зарчмыг баримтлаагүй байх	Дунд	Их	Дунд
2	Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах ажлын хэсэгт хууль тогтоомжид хамтран боловсруулахаар заасан байгууллага, ТББ, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаач, мэргэжлийн холбоод зэрэг журамд заасан төлөөлүүдийг оролцуулаагүй байх	Дунд	Дунд	Дунд
3	Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахад тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлоогүй, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийгээгүй байх	Дунд	Дунд	Дунд
4	Төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын нөхцөл байдлын дүн шинжилгээ, бодлогын хувилбарыг боловсруулах ажлыг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлээгүй байх	Дунд	Дунд	Дунд
5	Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах шатанд асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулаагүй байх;	Дунд	Дунд	Дунд
5	Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах шатанд бодлогын хувилбарыг хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т заасан шалгуурын дагуу үнэлээгүй байх	Бага	Дунд	Дунд
6	Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөөгүй байх	Дунд	Дунд	Дунд
7	Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгаагүй байх	Дунд	Дунд	Дунд
8	Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан бодлогын баримт бичгийн төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, зөвшөөрөл аваагүй байх	Бага	Дунд	Дунд
9	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэлээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг зохион байгуулаагүй байх	Бага	Дунд	Дунд
10	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөөгүй байх	Их	Дунд	Их
11	Бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байх	Дунд	Дунд	Дунд

12	Хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т заасан журмыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага батлаагүй байх	Их	Их	Их
13	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэгч байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгээгүй байх	Дунд	Дунд	Дунд
14	"Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам" нь бусад хууль тогтоомжтой нийцээгүй байх	Бага	Их	Дунд
15	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журамд заасан хугацаанд тайлагнаагүй байх	Их	Дунд	Дунд
16	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохих маягтын дагуу тайлагнаагүй байх	Дунд	Дунд	Дунд
Нийт эрсдлийн үнэлгээ		Дунд		

"Бага" гэж үнэлсэн Байхгүй

"Дунд" гэж үнэлсэн 14

"Их" гэж үнэлсэн 2

"Нийт эрсдлийн үнэлгээ" Дунд

Материаллаг байдлын түвшин

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж, боловсруулж баталдаг болсон байх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, тогтоомжийн дагуу тайлагнаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хуульд нийцүүлэн хийдэг болсон байх;
- Бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан байх.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах төлөвлөгөө боловсруулан ажилласан уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулсан уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, хууль, журамд заасан /бүтэц, агуулга, хүснэгт/ хүрээнд боловсруулж олон нийтээр хэлэлцүүлсэн үү?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, хууль, журамд заасан /бүтэц, агуулга, хүснэгт/ хүрээнд боловсруулж олон нийтээр хэлэлцүүлсэн үү?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг журамд заасны дагуу зохих байгууллагад хүргүүлж зөвшөөрөл авч эрх бүхий этгээдээр батлуулсан уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлсэн үү?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, хууль, журамд заасан /бүтэц, агуулга, хүснэгт/ хүрээнд боловсруулж олон нийтээр хэлэлцүүлсэн үү?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнасан уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлагнасан уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулж байна уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу зохион байгуулж байна уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилыг хууль, журмын дагуу зохион байгуулж байна уу?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, ага эзлийн нэгдсэн Удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, ЗДТГ хууль, журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Хэвлэгээ №2

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, ЗДТГ хууль, журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитын нэр: "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт"

Аудитын код: УАГ-НАГ/2017/07-НА

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙЛ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙЛ (Олж авсаны дараа бид юу хийж вэ?)
Үндсэн зорилт: Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлagnах, мэдээлэх үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?					
A. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомжийд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан уу?					
A.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах төлөвлөгөө боловсруулан ажилласан уу?	- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-5.1.7 дахь заалт - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7, 8, 9, 10, дугаар зүйлийн 7.2, 8.5, 9.3.3- 9.4, 10.1-10.3, дахь заалт - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт -Хууль тогтоомжийн тухай хуулийн 8-9 дүгээр зүйл, -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 10-19 дахь заалт.	-Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт -Төрөөс баримтлах бодлого Бүсчилсэн хөгжлийн бодлого Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогын баримт бичигүүд Төрийн захиргааны төв байгууллага ёөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичигүүд -Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр -Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр -Улсын здийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл Аймаг, нийслэл, сум, дүүргийн здийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл -УИХ, иргэдийн ТХ-аас өгсөн чиглэлийн дагуу гаргасан удирдамж болон боловсруулахаар байгуулсан ажлын хэсгийн ажлын баримт, судалгаа - 3Г, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллага, терийн болон нутгийн захиргааны байгууллага ёөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө түүнд заагдсан хүрэх түвшинг - Аймаг, нийслэл, сум дүүргийн Тамгын газрын дэргэдэх Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дэргэдэх Хяналт шалгалт, үнэлгээний албанаас хийсэн хяналт, шалгалт, үнэлгээ хийсэн тайлан, статистик мэдээ, тайлан	-УИХ, -ЗГХЭГ, -Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтэс -Сангийн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс -Яам, байгууллагууд, -Тухайн шатны ИТХ, - Тухайн шатны ЗДТГ-ын нэгжүүд -Иргэдийн мэдээлэл, -Эрдэм шинжилгээний Байгууллага, -ТББ судалгааны ажилд орсон -цахим хуудас -Хяналтын ажлын тайлангууд - Мөрдөж буй хууль эрх зүйн актууд - Төрийн болон нутгийн захиргааны байгууллагийн мэдээллийн сан	-Холбогдох баримт материалтай танилцах, - Шалгах хуудас ашиглах, - Судалгаа хийх, - Тайлбар мэдээ гаргуулах, - Ярилцлага хийх - Харьцуулсан судалгаа хийх, - Аудитын бусад горим, арга зүй	Баталгаажуулалт хийх - Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах.
A.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дун шинжилгээ хийн, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулсан уу?	-Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-17.3 дахь заалт, -Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 -12 дугаар зүйл, -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 20-23 дахь заалт,				
A.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, хууль, журамд заасан /бүтэц, агуулга, хүснэгт/ хүрээнд боловсруулж олон нийтээр хэлэлцүүлсэн үү?	- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-17.3 дахь заалт, -Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 -12 дугаар зүйл, -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 24-26 дахь заалт,				

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
A.4. Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дун, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцоололыг бодитой тусгасан уу?	-Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-17.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дэх хэсэг, -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 51-65 дахь заалт.			-УИХ, -ЗГХЭГ, -Үндэсний хөгжлийн газрын Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтэс	Баталгаажуулалт хийх - Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах.
A.5. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг журамд заасны дагуу зохих байгууллагад хүргүүлж зөвшөөрөл авч эрх бүхий этгээдээр батлуулсан уу?	-Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 зүйлийн 10.3 дахь хэсэг. -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 31 дэх заалт.	-Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал -Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт -Төрөөс баримтлах бодлого -Бүсчилсэн хөгжлийн бодлого -Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогын баримт бичигүүд -Төрийн захиргааны төв байгууллага ёөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичигүүд -Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр -Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр -Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл -УИХ, иргэдийн ТХ-аас өгсөн чиглэлийн дагуу гаргасан удирдамж болон боловсруулахаар байгуулсан ажлын хэсгийн ажлын баримт, судалгаа	-Сангийн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс -Яам, байгууллагууд, -Тухайн шатны ИТХ, - Тухайн шатны ЗДТГ-ын нэгжүүд -Иргэдийн мэдээлэл, -Эрдэм шинжилгээний Байгууллага, -ТББ судалгаа, -цахим хуудас -Хяналтын ажлын тайлангууд - Мөрдөж буй хууль эрх зүйн актууд	-Холбогдох баримт материалтай танилцах, - Судалгаа хийх, - Тайлбар мэдээ гаргуулах, -Ярилцлага хийх - Харьцуулсан судалгаа хийх, - Аудитын бусад горим, арга зүй	
A.6. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, төслийг нэгтгэн боловсруулах чиг үүргээ бүхий байгууллага хууль журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлсэн үү?	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3, 10 дугаар эйлийн 10.2, 10.3, 10.5, 10.6, 12 дугаар эйлийн 12.2, 12.3, 12.4, 12.6, 12.7, 12.8, 12.9, 13 дугаар зүйлийн 13.5, 14 дүгээр зүйлийн 14.2, 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэг. -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 10-34 дэх заалт.	-ЗГ, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага ёөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө түүнд заасан хүрэх түвшинг - Аймаг, нийслэл, сум дүүргийн Тамгын газрын дэргэдэх Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дэргэдэх Хяналт шалгалт, үнэлгээний албанаас хийсэн хяналт, шалгалт, үнэлгээ хийсэн тайлан, статистик мэдээ, тайлан, - Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 1-5 дугаар хавсралтаар гаргасан баримтууд.			
Б. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлagnаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үү?					
B.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журамд заасан хугацаанд тайлagnасан уу?	Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичиг: -Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар эйлийн 7.5, 8 дугаар зүйлийн 8.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 10 дугаар зүйлийн 10.7, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1 дэх хэсэг.	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал -Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт -Төрөөс баримтлах бодлого -Бүсчилсэн хөгжлийн бодлого -Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогын баримт бичигүүд -Төрийн захиргааны төв байгууллага ёөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичигүүд -Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр -Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл	-Аудитад хамрагдах байгууллагын удирдлага болон холбогдох эрх бүхий этгээд, -Сангийн яам, -ЗГХЭГ	-Холбогдох баримт материалтай танилцах, - Шалгах хуудас ашиглах, - Судалгаа хийх, - Тайлбар мэдээ гаргуулах,	-Нэгтгэн дүгнэх аргыг ашиглах, -Шинжилгээ хийх, -Баталгаажуулалт хийх - Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦҮГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
		<p>ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр</p> <p>-Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх ундсэн чиглэл</p> <p>-УИХ, иргэдийн ТХ-аас егсэн чиглэлийн дагуу гаргасан удирдамж болон боловсруулахаар байгуулсан ажлын хэсгийн ажлын баримт, судалгаа</p> <p>-ЗГ, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө түүнд заасан хүрэх түвшинг</p> <p>-Аймаг, нийслэл, сум дүүргийн Тамгын газрын дэргэдэх Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дэргэдэх Хяналт шалгалт, үнэлгээний албанаас хийсэн хяналт, шалгалт, үнэлгээ хийсэн тайлан, статистик мэдээ, тайлан.</p>		<p>- Ярилцлага хийх</p> <p>- Харьцуулсан судалгаа хийх,</p> <p>-Аудитын бусад горим, арга зүй</p>	төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд ундэслэн санал, дүгнэлт боловсруулах.
Б.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хуулиар тодорхойлсон хугацаанд холбогдох байгууллагад танилцуулж байна уу?	<p>- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 8 дугаар зүйлийн 8.6, 10 дугаар зүйлийн 10.7 дэх хэсэг.</p> <p>Орон нутгийн хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 15.7, 15.8 дахь хэсэг. -Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтооолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 60 дахь заалт. 	<p>Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал</p> <p>-Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт</p> <p>-Төрөөс баримтлах бодлого</p> <p>-Бусчилсан хөгжлийн бодлого</p> <p>-Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогын баримт бичигүүд</p> <p>-Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичигүүд</p> <p>-Үндэсний хөтөлбөрийн жагсаалт,</p> <p>-Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөрийн жагсаалт, хэрэгжүүлэх төлөвлөгөө,</p> <p>-Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, тайлан,</p> <p>- Бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтан,</p> <p>- Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 89 дүгээр журмын 7, 8 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мөн журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлнэ.</p>			
Б.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнзлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?	<p>-Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-7.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.5, 9 дүгээр зүйлийн 9.3.3, 10 дугаар зүйлийн 10.6, 13 дугаар зүйлийн 13.6, 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, 15.4 дэх хэсэг,</p> <p>-Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтооолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 7 дахь заалт,</p> <p>-Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтооолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 66-69 дэх заалт.</p>				
В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?					
B.1. Хөгжлийн	- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22	-терийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны	-терийн захиргааны	-Холбогдох	-Нэгтгэн дүгнэх

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦҮГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байна уу?	дугаар зүйлийн 22.1-22.6 дахь заалт, -Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 10 дугаар бүлэг, -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 27-30 дахь заалт.	байгууллагаас баримт бичгийг боловсруулахдаа хийсэн хэлэлцүүлэгийн баримт бичиг Үнд: ○ -хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хийсэн ○ эрдэмтэн судлаач, шинжээчийн хүрээнд ○ тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд ○ төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд -төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дээрх хэлэлцүүлгийн дагуу баримт бичигт тусгасан эс тусгасан талаарх баримт болон төслийн олон нийтэд мэдээлсэн талаарх баримт.	төв байгууллага, тухайн шатны нутгийн захиргааны байгууллага	баримт материалтай танилцах, - Шалгах хуудас ашиглах, - Судалгаа хийх, - Тайлбар мэдээ гаргуулах, - Ярилцлага хийх - Харьцуулсан судалгаа хийх, - Аудитын бусад горим, арга зүй	аргыг ашиглах, -Шинжилгээ хийх, -Баталгаажуулалт хийх Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах.
В.2. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, ЗДТГ хууль, журамд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?	- Хөгжлийн бодлого төлөвлөтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-7.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.5, 9 дүгээр зүйлийн 9.3.3, 10 дугаар зүйлийн 10.6, 13 дугаар зүйлийн 13.6, 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, 15.4 дахь хэсэг, -Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 66-69 дахь заалт, -Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 7 дугаар бүлэг.	-Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал -Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн эорилт -Төрөөс баримтлах бодлого -Бүсчилсэн хөгжлийн бодлого -Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогын баримт бичигүүд -Төрийн захиргааны төв байгууллага ёөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичигүүд -Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр -Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр -Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл -УИХ, иргэдийн ТХ-аас өгсөн чиглэлийн дагуу гаргасан удирдамж болон боловсруулахаар байгуулсан алжын хэсгийн ажлын баримт, судалгаа - ЗГ, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага ёөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө түүнд заасан хүрэх түвшинг - Аймаг, нийслэл, сум дүүргийн Тамгын гаэрын дэргэдэх Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дэргэдэх Хяналт шалгалт, үнэлгээний албанаас хийсэн хяналт, шалгалт, үнэлгээ хийсэн тайлан, статистик мэдээ, тайлан, - Дотоод аудитын тайлан Төрийн болон нутгийн захиргааны байгууллагийн холбогдох хэлтэс албаны тайлан, мэдээ, танилцуулга.	-Тухайн байгууллагын дотоод аудитын алба -Иргэд -Бусад байгууллага, албан тушаалтан	-- Холбогдох баримт материалтай танилцах, - Шалгах хуудас ашиглах, - Судалгаа хийх, - Тайлбар мэдээ гаргуулах, - Ярилцлага хийх - Харьцуулсан судалгаа хийх, - Аудитын бусад горим, арга эүй	-Нэгтгэн дүгнэх аргыг ашиглах, -Шинжилгээ хийх, -Баталгаажуулалт хийх Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах.